



## ХУВЬЦАА ГЭЖ ЮУ ВЭ?

**Хувьцаа гэдэг нь:** компанийн тодорхой хэсгийг эзэмших эрхийг хэлэх буюу компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаас юм.

## ХУВЬЦААНЫ ТӨРЛҮҮД

Үнэт цаас гаргагч компани **үндсэн 2 төрлийн** хувьцааг санал болгодог.

01

### Энгийн хувьцаа /common stock/

**Энгийн хувьцаа эзэмшигч** ихэнхдээ тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох бөгөөд ногдол ашиг авах эрхтэй.

### Давуу эрхийн хувьцаа /preferred stock/

**Давуу эрхийн хувьцаа эзэмшигч** саналын эрхгүй боловч тогтмол хэмжээний ногдол ашгийг энгийн хувьцаа эзэмшигчээс түрүүлж авах эрхтэй.

02

## ХУВЬЦААНЫ ДАВУУ БА СУЛ ТАЛ

### Давуу тал



1. Хөрвөх чадвар сайн
2. Ханшийн зөрүүнээс ашиг олох
3. Хувьцааны үнэ цэн өсөх магадлал их
4. Ногдол ашиг хүртдэг
5. Хөрөнгөө өөрөө удирдах боломжтой



### Сул тал

1. Хөрөнгө үнэ цэнээ алдах
2. Удаан хугацааны хүлээлт
3. Хадгаламжид байснаас эрсдэл өндөртэй
4. Гадаад, дотоод олон хүчин зүйлсээс хамаардаг
5. Компани нь дампуурах эрсдэлтэй

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ



Ээлжит болон ээлжит бус  
хуралд оролцох, санал өгөх



Компанийн тайлан  
мэдээлэлтэй танилцах



Эрх ашгаа хамгаалуулах  
талаар гомдол гаргах

## ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭХ ЗААВАР



Яаж данс нээдэг  
юм бол доо?  
.....

Би танд  
заагаад өгье.



01

Та өөрт тохиромжтой  
брокерын компанийг  
сонгоно.

02

Брокер дээр очиж,  
эсвэл цахимаар  
дансаа нээлгэнэ.

03

Хамгийн сүүлд нь данс  
нээлгэх хураамжаа  
**/5,000–10,000/** төлөөд л  
болоо



### АНХААРАХ ЗҮЙЛС:

- Мэдээллээ үзэн зөв бөглөх, мэдээллээ алдахаас сэргийлэх
- Гарын үсгээ зурахаас өмнө арилжааны шимтгэлийн хувь **/1–3%/**, хугацаа зэргийг сайтар анхаарах
- Арилжаанд орохдоо тухайн хувьцааны талаар судлах